

Огноо: 2026.02.06

№ 18

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын  
бүрэн эрхийг дуусгавар болгох тухай**

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.10 дахь хэсэг, “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 4.4.1, 4.5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан Б.Тэлмүүний Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийг 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрөөр тасалбар болгон дуусгавар болгосугай.

2. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын түр эзгүй байх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын чиг үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Г.Золбоогоор гүйцэтгүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГЭГЧ



С.ЦЭНД-АЮУШ